



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/16/НА-СА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716	Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Цахим хаяг: namchinsureng@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.4.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага	13
3.5.3 Урьдчилгаа	13
3.5.4 Бараа материал	13
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	14
3.5.6 Үндсэн хөрөнгө	14
3.5.7 Өр төлбөр	15
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.7.1 Завсрын аудитын талаар.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 236
танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Х.ХАЛИУНБАТ ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бугат сумын ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 25,751.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,826.0 мянган төгрөгөөр давж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20.2.3, 20.2.6, 20.2.9, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.6, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2, 71.3 заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүхэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд бэлтгэсэн 15,000.0 мянган төгрөгийн өвсийг бүртгэл тайлант тусгаагүй;
- Шатахуун зарцуулахдаа 100 км-т баримтлах нормыг баримтлаагүй 281.0 мянган төгрөгийг илүү тооцон олгосон;
- Урьдчилан олгосон 500.0 мянган төгрөгийг суутган тооцоолоогүй, бүртгэл тайланд авлагаар бүртгээгүй;
- НӨАТ-ын баримтгүй нийт 5,980.0 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн;
- Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 3,990.8 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

000020525

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Бугат сумын ЗДТГ нь өөрийн байрны гадаад, дотоод бүрэн засвар хийсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 50.5 хувиар өссөн байна.

Бусад мэдээлэл

Тус байгууллага нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 96 хувиар үнэлжээ.

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	487,364.51	486,546.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	164,783.82	176,935.67
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0	0
33	АВЛАГА	241,158.49	237,440.14
34	УРЬДЧИЛГАА	0	0
35	БАРАА МАТЕРИАЛ	81,422.20	72,170.39
36	НӨӨЦИЙН БАРАА	0	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,354,132.92	2,345,344.66
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0	0
37100	Урт хугацаат хадгаламж	0	0
37200	Үнэт цаас	0	0
37300	Урт хугацаат зээл	0	0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,354,132.92	2,345,344.66
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	1,221,280.92	2,184,537.66
39300	Биет бус хөрөнгө	132,852.00	160,807.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,841,497.43	2,831,890.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,583.47	9,789.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,583.47	9,789.20
41100	Богино хугацаат үнэт цаас	0	0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0	0
41210	Төгрөг	0	0
41300	Өглөг	3,583.47	9,789.20
42100	Урт хугацаат үнэт цаас	0	0
42200	Урт хугацаат зээл	0	0
42210	Төгрөг	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,837,913.96	2,822,101.66
51	Засгийн газрын хувь оролцоо	1,837,913.96	2,822,101.66
51100	Засгийн газрын оруулсан капитал	672,610.81	672,610.81
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0	0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	672,610.81	672,610.81
51200	Хуримтлагдсан үр дүн	717,493.27	1,702,452.02
51210	Өмнөх үеийн үр дүн	4,573,014.96	736,090.10
51220	Тайлант үеийн үр дүн	-3,855,521.70	966,361.92
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0	0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447,809.88	447,038.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,841,497.43	2,831,890.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,281,535.44	3,052,393.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	263,196.17	327,799.21
110	Орлогын албан татвар	117,462.79	160,186.61
1100	Хувь хүний орлогын албан татвар	117,462.79	160,186.61
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0	0
1103	ААН-ын орлогын албан татвар	0	0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0	0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0	0
113	Хөрөнгийн албан татвар	62,287.86	62,847.86
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0	0
115	Онцгой албан татвар	0	0
116	Тусгай зориулалтын орлого	0	0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0	0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,445.52	104,764.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	261,823.54	1,102,268.58
120	Нийтлэг татварын бус орлого	261,823.54	1,102,268.58
121	Хөрөнгийн орлого	0	0
122	Тусламжийн орлого	0	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	0
124	Зээлийн орлого	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,756,515.73	1,622,325.41
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,999,649.43	1,862,485.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,999,649.43	1,862,485.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,070,368.78	1,536,783.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,170.23	472,628.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,058.35	51,460.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	300,059.39	59,002.49
2104	Хангамж, бараа материалын зардал	55,392.42	80,349.09
2105	Нормативт зардал	0	900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,291.00	12,250.20
2107	Томилолт, зочны зардал	6,368.00	5,729.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,993.45	88,455.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	382,035.95	766,006.55
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	929,280.65	325,702.95
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	281,886.01	1,189,907.25
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,137,407.70	223,545.33
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,855,521.70	966,361.92

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,484,959.37	1,050,046.84	3,242,037.05	5,777,043.27
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	672,610.81	447,809.88	717,493.27	1,837,913.96
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	672,610.81	447,809.88	4,573,014.96	5,693,435.66
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-812,348.56	-602,236.96	1,330,977.91	-83,607.61
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-3,855,521.70	-3,855,521.70
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	672,610.81	447,809.88	717,493.27	1,837,913.96
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	672,610.81	447,038.83	1,702,452.02	2,822,101.66
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	672,610.81	447,809.88	736,090.10	1,856,510.79
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	18,596.83	18,596.83
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-771.05	0	-771.05
19	Тайлант үеийн үр дүн	0	0	966,361.92	966,361.92

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,123,599.29	2,054,593.57
11	ТАТВАРЫН ОРЛОГО	263,196.17	327,799.21
110	Орлогын албан татвар	117,462.79	160,601.62
1100	Хувь хүний орлогын албан татвар	117,462.79	160,601.62
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0	0
1103	ААН-ын орлогын албан татвар	0	0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0	0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0	0
113	Хөрөнгийн албан татвар	62,287.86	62,847.86
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0	0
115	Онцгой албан татвар	0	0
116	Тусгай зориулалтын орлого	0	0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0	0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,445.52	104,349.74
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,519.36	19,528.87
1181	Газрын төлбөр	17,962.73	20,550.02
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	41,963.43	64,270.84
1183	Бусад татвар	0	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,463.76	101,988.94
120	Нийтлэг татварын бус орлого	102,463.76	101,988.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	83,478.08	58,264.61
121	Хөрөнгийн орлого	0	0
122	Тусламжийн орлого	0	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,757,939.35	1,624,805.41

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,876,986.00	1,753,537.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,876,986.00	1,753,537.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	933,936.08	1,745,815.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,191.81	471,172.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,058.35	49,572.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	300,059.39	59,002.49
2104	Хангамж, бараа материалын зардал	23,901.05	35,154.97
2105	Нормативт зардал	800.00	900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,482.50	16,746.20
2107	Томилолт, зочны зардал	6,312.00	5,729.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,639.45	90,186.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	275,491.53	1,017,352.40
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	943,049.92	7,721.81
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	246,613.29	301,055.97
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	179,812.00	238,304.35
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	179,812.00	238,304.35
2200	Дотоод эх үүсвэрээр	179,812.00	238,304.35
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-179,812.00	-238,304.35
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-81,087.50	-50,599.77
14	Бусад эх үүсвэр	0	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	81,087.50	50,599.77
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0	0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-14,286.21	12,151.85
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	179,070.03	164,783.82
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	164,783.82	176,935.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,661,577.20	1,402,332.40	406,202.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,220,603.20	1,129,365.19	133,235.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,218,503.20	1,127,265.19	133,235.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,844.10	471,172.18	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,855.60	49,572.52	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	351,653.90	331,186.84	64,047.69
2104	Хангамж, бараа материалын зардал	36,077.70	35,704.97	0
2105	Нормативт зардал	900.00	900.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,320.90	70,217.50	4,400.00
2107	Томилолт, зочны зардал	7,642.00	5,729.00	0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,728.30	90,186.03	64,787.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,480.70	72,596.15	0
211	ХҮҮ	0	0	0
212	ТАТААС	0	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,100.00	2,100.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	307,228.40	222,367.45	222,367.45
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	133,745.60	50,599.77	50,599.77
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,661,577.20	1,403,171.99	401,238.54
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	-961,961.75
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,407,452.40	1,344,907.39	1,347,721.18
320001	Орон нутгийн төсвөөс	1,242,442.80	1,181,206.39	1,184,020.18
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	165,009.60	163,701.00	0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	0
34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	254,124.80	58,264.61	15,479.11
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0	0	0
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0	0	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	52	52	52
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	25
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25	25

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр / ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	639,487.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	639,487.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	639,487.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0
2104	Хангамж, бараа материалын зардал	0
2105	Нормативт зардал	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0
2107	Томилолт, зочны зардал	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	639,487.51
211	ХҮҮ	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0
2200	Дотоод эх үүсвэрээр	0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	639,487.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	639,487.51
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нь бүрэн эрхийнхээ хугацаанд Нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлж “Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг чанд баримтлан, үйл ажиллагаандаа Ардчилсан-Шударга ёсыг удирдлага болгон орон нутагт тулгамдаж буй нийгэм, эдийн засгийн аливаа асуудлыг нийгмийн хэрэгцээ, иргэдийнхээ эрхийг дээдлэн хүндэлж, ил тод байдлыг ханган ажиллах эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэх эрүүл мэндийн чанарын хүртээмж сайжруулна;
- Биеийн тамираар хичээллэх орчин бүрдүүлэх зорилгоор биеийн тамирын тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжлийн холбоодтой хамтрах;
- Нийгмийн хамгааллын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны болон, хүүхэд хамгааллыг сайжруулж гэр бүл хамгааллын төв байгуулах жендерийн тэгш байдлыг хангах;
- Хүүхэд бүрийг СӨБ, ЕБС-ийн үйлчилгээнд хамруулах Монгол сэтгэлгээг төлөвшүүлэх;
- Төв суурингийн ногоон байгууламжийн төлөвлөлтийг боловсронгуй болгож ногоон сум болгон хөгжүүлнэ;
- Мал сүргийн бүтцийг зохистой болгож үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх;
- Нийтийн хэв журмыг сахиулж аюулгүй байдлыг хангаж иргэнд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэх;
- Нийт суурьшлын бүсийг хаягжуулж дэд бүтцийг хөгжүүлж иргэдийг амьдрах таатай нөхцөлөөр хангах;
- Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийг бууруулах менежментийн тогтолцоог бүрдүүлнэ;
- Санхүүгийн ил тод байдлын дагуу үр ашигтай зарцуулалт, баримт бичгийн зөрчилгүй болно;
- Авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, ёс зүйг өндөржүүлж, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж төрийн албаны сахилга батыг сайжруулах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Нийгмийн даатгалын тухай хууль Татварын тухай хууль Төрийн албаны тухай хууль Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын 2023 оны санхүүгийн тайлан дахь Тайлант онд баталсан татварын болон татварын бус орлогыг мөнгөн сууриар хөтөлж, ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 990.39 сая төгрөгөөр буюу 53.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	164.78	176.94	12.15
Авлага	241.16	237.44	(3.72)
Бараа материал	81.42	72.17	(9.25)
Үндсэн хөрөнгө	1,354.13	2,345.34	991.21
Нийт хөрөнгө	1,841.50	2,831.89	990.39
Өр төлбөр	3.58	9.79	6.21
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,837.91	2,822.10	984.19
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,841.50	2,831.89	990.39

Эх сурвалж: Бугат сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 208.21 сая төгрөг болж, өмнөх оноос 123.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	164.7	176.9	12.2
Төгрөг	164.7	176.9	12.2
Төрийн сангийн харилцах	164.7	176.9	12.2
Дүн	164.7	176.9	12.2

Эх сурвалж: Бугат сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 176.9 сая төгрөг нь 12.2 сая төгрөгөөр өссөн нь ОНХО-ын дансны үлдэгдэл 11.3 сая, ОНХС-гийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл 6.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Төрийн сангийн 176.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ОНХО-ын дансанд 67.2 сая төгрөг, ОНХС-д 54.8 сая төгрөг, хоршоо хөгжүүлэхийн дансанд 44.8, Байгаль хамгаалах сангийн дансанд 7.5 сая төгрөг, ЖДҮДС-гийн дансанд 2.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 237.4 сая төгрөг болж, өмнөх оноос 3.72 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	4.03	2.89	(1.14)
Байгууллагаас авах авлага	3.70	1.22	(2.48)
Хувь хүмүүсээс авах авлага	232.91	233.22	0.31
Дүн	241.16	237.44	(3.72)

Эх сурвалж: Бугат сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Авлага дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 55.8 сая төгрөг буюу 23.53 хувийг ЖДҮДС-ийн зээл болон зээлийн хүүгийн авлага, 155.4 сая төгрөг буюу 65.4 хувийг ХХС-ийн зээл болон зээлийн хүүгийн авлага, 4.1 сая төгрөг буюу 1.7 хувийг ЗДТГ, 2.0 сая төгрөг буюу 0.8 хувийг ОНХО-ын авлага, 20.0 сая буюу 8.4 хувийг ОНХС-гийн авлагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- ЖДҮДС-гаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлагыг тооцоо нийлж баримтжуулаагүй, хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 0.0 сая төгрөг байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0	0	0
Урьдчилгаа тооцоо	0	0	0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Дүн	0	0	0

Эх сурвалж: Бугат сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 72.2 сая төгрөг болж, өмнөх оноос 9.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бэлэн бүтээгдэхүүн	2.7	0.0	-2.7
Хангамжийн материал	54.9	49.1	-5.7

Бичиг хэргийн материал	1.5	0.7	-0.8
Бусад хангамжийн материал	22.3	22.3	0.0
Мал амьтад	0.0	0.0	0.0
Дүн	81.4	72.2	-9.3

Эх сурвалж: Бугат сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Бараа материалын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл ЗДТГ 72.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд ЗДТГ 2.9, ИТХ 6.3 сая төгрөгөөр бараа материал буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр тайлант онд бэлтгэсэн 4.0 сая төгрөгийн өвсний үлдэгдлийг жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй. /БХС/
- Тайлант онд бэлтгэсэн 15.0 сая төгрөгийн тэжээлийн будааг бүртгэл тайланд тусгаагүй, мөн жилийн эцсийн тооллогоор тоологдоогүй. /БХС/

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 0.0 сая төгрөг болж, өмнөх оноос 0.0 сая төгрөг буюу өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	0	0	0
Дүн	0	0	0

Эх сурвалж: Бугат сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,345.3 сая төгрөг болж, өмнөх оноос 991.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	796.82	1102.41	305.58
Авто-тээврийн хэрэгсэл	69.06	67.94	-1.13
Машин тоног төхөөрөмж(компьютер)	90.07	108.67	18.61
Тавилга, аж ахуйн эд хогшил	17.32	92.47	75.16
Зам гүүрийн байгууламж	0.00	397.22	397.22
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	0.00	0.00	0.00
Түүх соёлын дурсгалт зүйл	16.28	16.08	-0.20
Дуусаагүй барилга байгууламж	0.00	0.00	0.00
Номын фонд	0.93	0.51	-0.42
Бусад үндсэн хөрөнгө	230.79	399.23	168.44
Программ хангамж	0.36	0.32	-0.05
Бусад биет бус хөрөнгө	132.49	160.49	28.00
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00	0.00
Дүн	1354.13	2345.34	991.21

Эх сурвалж: Бугат сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 2,310.3 сая төгрөг буюу 98.5 хувийг ЗДТГ, 35.0 сая төгрөг буюу 0.01 хувийг ИТХ-ын авлагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Тайлант онд ЗДТГ-ын үндсэн хөрөнгө 965.0, ИТХ-ын үндсэн хөрөнгө 26.1 сая төгрөгөөр

тус тус нэмэгдсэн нь ЗДТГ байранд бүрэн засвар хийгдсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгө худалдан авсан, сумын 100 жилтэй холбоотойгоор хандиваар өгсөнтэй холбоотой байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 9.79 сая төгрөг болж, өмнөх оноос 6.21 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	3.58	9.79	6.21
Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	2.21	2.21
Бусад өглөг	3.58	7.58	4.00
Байгууллагад төлөх өглөг	3.58	7.58	4.00
Дүн	3.58	9.79	6.21

Эх сурвалж: Бугат сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ЗДТГ 23 хувь буюу 2.2 сая төгрөгийн, ХХС 12 хувь буюу 1.1 сая төгрөгийн, ОНХС 66 хувь буюу 6.4 сая төгрөгийн өглөгийг эзэлж байна.

Тайлант онд өглөг өсөхөд ЗДТГ-ын НДШ-ийн өглөг шинээр үүссэн, ОНХС-гийн халуун усны засварын ажил өглөг 4.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,772.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,024.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	672.61	672.61	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	717.49	1,702.45	984.96
Өмнөх үеийн үр дүн	4,573.01	736.09	(3,836.92)
Тайлант үеийн үр дүн	(3,855.52)	966.36	4,821.88
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447.81	447.04	(0.77)
Дүн	1,837.91	2,822.10	984.19

Эх сурвалж: Бугат сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Засгийн газрын хувь оролцоо өмнөх оны үлдэгдлээс 53.5 хувиар өссөн нь тайлант оны үйл ажиллагааны нийт үр дүн 966.3 сая төгрөг буюу эерэг үзүүлэлтэй гарсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний IX/04 тоот тогтоолоор сумын 2023 оны төсвийг 1,345.0 сая төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 355.0 сая төгрөгөөр, аймгаас олгох санхүүжилт 685.5 сая төгрөг, ОНХС-гаас олгох шилжүүлэг 254.4 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 2.0 сая төгрөг, 2022 оны малын хөлийн татвараас сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах дүн 84.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 28-ны IX/01 тоот тогтоолоор сумын 2023 оны төсвийг тодотгон 1,493.2 сая төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 354.3 сая төгрөгөөр, ОНХС-гаас олгох шилжүүлэг 129.9 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 761.1 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 6.3 сая төгрөгөөр, 2022 оны малын хөлийн татвараас сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах дүн 84.0 сая төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,402.3 сая төгрөг, ОНХС-гаас 352.7 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 6.8 сая төгрөг, СХС-аас 47.0 сая төгрөгийн зээл төлөгдөж, орлого 27.1 сая төгрөгөөр дутуу биелсэн нь малын тоо толгойн татвар дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,402.3 сая төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсөв, ОНХС-гаас 76.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	124.6	122.8	1.8	98.6%
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	897.1	739.2	158.0	82.4%
3	Орон нутгийн зорилтот Хөрөнгө оруулалт	307.2	222.4	84.9	72.4%
4	Соёл урлаг	23.5	22.3	1.2	94.9%
5	Сургуулийн өмнөх боловсрол	50.9	47.3	3.5	93.0%
6	Ерөнхий боловсрол	186.8	179.9	6.9	96.3%
7	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	71.5	68.4	3.0	95.8%
	Нийт	1661.6	1402.3	259.2	84.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ-ын өөрийн үйл ажиллагааны орлого болох түрээсийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн.
- Шатахуун зарцуулахдаа 100 км баримтлах норм, нормативыг баримтлаагүй 0.2 сая төгрөгийг илүү зарцуулсан./ЗДТГ/
- Тайлан хугацаанд 1 албан хаагчаас 0.5 сая төгрөгийн урьдчилгаа цалинг суутгаагүй /ЗДТГ/
- НӨАТ-ын баримтгүй 5.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн /ЗДТГ/
- Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох журмыг баримтлаагүй 3.9 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан./ЗДТГ/

- Шатахууны зардлыг тооцож олгохдоо автомашины 100 километр зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 0.6 сая төгрөгийн шатахууны зардлыг илүү олгосон./ИТХ/
- Тайлант онд хэрэгжүүлэхээр ИТХ-аар батлуулсан төсөл арга хэмжээний төсвийг 0.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 428.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хангал сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангал сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 01/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны үр дүнгийн тайлангийн өмнөх оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,999.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 29.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй

байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төсвийн шууд захирагчдын хүрээнд Төрийн хэмнэлтийн хуулийн 14.1, 15.1.5-ийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин нийт 10.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй./ЗДТГ/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 1.0 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл, хүнс худалдан авсан/ЗДТГ/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 0.5 сая төгрөгөөр санхүүчдийн баяр тэмдэглэсэн /ЗДТГ/
- Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль зөрчин хандив олгосон/ЗДТГ/
- Төсвийн хөрөнгөөр 0.4 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан./ИТХ/
- Тайлант онд 10.1 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, цахим дэлгүүрт хүсэлт хүргүүлээгүй./ИТХ/

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хангал сумын ТТЗ нь шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төсвийн шууд захирагчдын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн 6.4.5, 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим хуудсанд нийт 29 удаагийн нийт 562,725.3 мянган төгрөгийн таван сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй./ЗДТГ/
- Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш 11 удаагийн орлогын гүйлгээ, 13 удаагийн 9515.4 мянган төгрөгийн тухай хуулийн 6.4.5, 6.4.8 дахь заалтыг зөрчсөн зөрчилд нийт 115493860 төгрөгийн албан шаардлагыг хүргүүлээ./ИТХ/
- Шилэн дансны цахим хуудсанд таван саяаас дээш 16 удаагийн 257,455,974 төгрөгийн орлогын гүйлгээ, 8 удаагийн 144,025,350 төгрөгийн зарлагын гүйлгээ, 18 удаагийн 144,025,350 төгрөгийн хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй./ОНХС/
- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш 1 удаагийн 10,525.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байна./СХС/

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр 02/247 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	16.5	1	16.5	100
Албан шаардлага					
Зөвлөмж	2	25.5	2	25.5	100
Нийт дүн	3	42	3	42	100

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд¹ 59.8 сая төгрөгийн 2 албан шаардлага, 0.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 1,329.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.72 сая төгрөгийн 9 төлбөрийн акт тогтоож, 1,299.5 сая төгрөгийн 10 албан шаардлага хүргүүлж, 10.5 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

Илрүүлэлт:

Төсвийн тухай хуулийн 54.4.5 дахь заалтын дагуу тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.4.5, дахь заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт дагуу тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Соёлын төв	1	9.0	1	9.0			1	9.0				
Дүн	1	9.0	1	9.0			1	9.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ТТЗ	4	60.5	1	0.7	2	59.8	1						
ЗДТГ	5	25.66	2	0.78	2	18.9	1	5.98					
ИТХ	1	0.66	1	0.66									
ОНХС					1	0.8							
ХХС	1	0.09	1	0.09									
Дүн	11	86.91	5	2.23	5	79.5	2	5.98	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	1	562.7	0	0	1	562.7	0	0
ОНХС	1	521			1	521.0		
ХХС	1	10.5			0	0	1	10.5
ИТХ	1	115.49	0	0	1	115.49		
Дүн	4	1209.69	0	0	3	1199.19	1	10.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	4	13.78	3	3.08	1	10.7	0	0
ОНХС	0	0	0	0	0	0	0	0
ИТХ	2	10.56	1	0.42	1	10.14	0	0
Нийт дүн	6	24.34	4	3.5	2	20.84	0	0